**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 14 өдөр Дугаар А/687 Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “б”, Засгийн газрын 2017 оны “Хүнсний ногоо” хөтөлбөр баталсан 278 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны “Жимс, жимсгэнэ” хөтөлбөр баталсан 223 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүнсний ногоо хөтөлбөр хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө”, “Жимс, жимсгэнэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хэсгийг нэгдүгээр, “Хүнсний ногоо хөтөлбөр хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө”-г хоёрдугаар, “Жимс, жимсгэнэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө”-г гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжилтийг хангах, явц, үр дүнг тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. “Хүнсний ногоо хөтөлбөр хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө”, “Жимс, жимсгэнэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

011101471

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дугаар сарын 14 –ны өдрийн А/687 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

# “ХҮНСНИЙ НОГОО ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЙМГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”, “ЖИМС, ЖИМСГЭНЭ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЙМГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Г.Баясгалан- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Ариунаа- Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга

Гишүүд: С.Цэдэнбалжир- Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

С.Дуламсүрэн- Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга

Г.Мөнхтөр- Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга

Сумын Засаг дарга нар

-оОо-

Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/687 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

## “ХҮНСНИЙ НОГОО” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээ | Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хүрэх үр дүн | Хугацаа | Санхүүжилт | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндсэн | Хамтрагч |
| **1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулан, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх замаар өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг бууруулах** | | | | | | | |
| 1 | Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулахад хөнгөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах | Нарийнтээл, Төгрөг, Арвайхээр, Хархорин сумдад хүнсний ногооны төрөлжсөн өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх | Өвлийн хүлэмжийг 1 га талбайгаар нэмэгдүүлэх | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид ХХААГ гэх/, Сумын Засаг дарга нар | Тариалан эрхлэлтийг дэмжих сан /цаашид ТЭДС гэх/, Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага, Аж ахуй нэгж, иргэд |
| 2 | Орон нутагт зуны нийлэг хальсан хүлэмж байгуулахад зориулж хөнгөлттэй нөхцөлөөр дэмжлэг үзүүлж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх | Таримлыг төрөлжүүлэн тариалах бүсчилсэн төлөвлөгөөний дагуу төвийн болон өндөрлөг бүсийн сумдын газар тариалангийн салбарт шинэ зуны хүлэмжийг хөгжүүлэх | Зуны хүлэмжийн хэмжээг 2 га талбайгаар нэмэгдүүлэх | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга нар | ХХААХҮЯ, ТЭДС, Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага, Аж ахуй нэгж, иргэд |
| 3 | Хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургацын чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таримлын ургалтын үеийн био, органик, эрдэс бордоог хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх | Тариалангийн үйлдвэрлэлд шаардлагатай бордоо, ургамал, хамгааллын бодисыг Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 50 хувь хөнгөлөлттэй үнээр зээлээр олгуулах | Бүтээгдэхүүний үнэ буурч, ургацын хэмжээ нэмэгдэн, чанар сайжрана. Хөрсний үржил шим нөхөн сэргээгдэх болно. | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ | ХХААХҮЯ, ТЭДС, Сумын Засаг дарга нар , Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага, Аж ахуй нэгж, иргэд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хүнсний ногоо хатаах, хөлдөөх, хуурайшуулах, дэвшилтэт технологийг нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Нарийнтээл, Төгрөг, Арвайхээр, Хархорин сумдад хүнсний ногоог боловсруулах, даршлах, хатаах савлах, дахин боловсруулах үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх | Хадгалалтын шинэ технологи туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга | Аж ахуй нэгж, иргэд |
| **2. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх** | | | | | | | |
| 5 | Хүнсний ногоо үйлдвэрлэгчийн захиалгаар бага дунд оврын трактор, түүнд зориулсан чиргүүл дүүжин машин, мотоблок болон түүнд сольж угсардаг үрлэгч, арчлах, хураах техникийг нийлүүлэх ажлыг зохион байгуулах | Орчин үеийн технологид нийцсэн, бүтээмж өндөртэй техникийн шинэчлэл хийх, өрхийн болон фермерийн хэрэгцээнд нийцсэн бага, дунд хүчин чадалтай техник тоног төхөөрөмжийг зээлээр олгоход дэмжлэг үзүүлэх | Газар тариалангийн техникийн хангамж нэмэгдсэн байна | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга нар | ХХААХҮЯ, Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага Аж ахуй нэгж, иргэд |
| 6 | Хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд халгүй , хямд төсөр усалгааны арга болох дуслын усалгаа, хөрсөн дотроос нэвчүүлэх | Усалгааны дэвшилтэт арга технологи /дуслын, нэвчилтийн систем, намираа бороожуулагч/-ийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан санхүүгийн түрээс болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгуулж усалгаатай тариалангийн нэгжээс авах ургацыг | Усалгаатай тариалангийн хэмжээг 1944 га-д хүргэнэ | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга нар | ХХААХҮЯ, Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага Аж ахуй нэгж, иргэд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авалт /боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай/-аар дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах | ажил үйлчилгээ худалдан авахдаа орон нутагтаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд сонгон авахад анхаарч ажиллах | байгууллага хангагдаж, үйлдвэрлэгчдийн борлуулалт нэмэгдсэн байна | | | | бодлого төлөвлөлтийн хэлтэс / цаашид ХОХБТХ гэх/, Орон нутгийн Өмчийн газар /цаашид ОНӨГ гэх/, Аж ахуй нэгж, иргэд |
| **3. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 11 | Ногооны үр үйлдвэрлэл эрхлэгчдэд үрсэлгээ бойжуулах зориулалтын хүлэмжийн аж ахуйг байгуулахад нь дэмжлэг үзүүлэх | Нарийн ногооны үрийн хангамжийг сайжруулах, иргэд аж ахуйн нэгжүүдэд баталгаатай сайн чанарын сонгины үр үйлдвэрлэж нийлүүлэхэд Япон улсын Хаккойда мужийн Такикава хотын Гадаад харилцааны хэлтэстэй хамтран газар тариалангийн чиглэлээр “Агро-бизнесийг хөгжүүлэх” төсөл хэрэгжүүлж зориулалтын хүлэмжийн аж ахуй байгуулахад арга зүйн болон үрийн дэмжлэг үзүүлэх | Бөөрөнхий сонгины нутагшсан үр үржүүлж, орон нутгийн үйлдвэрлэл, хэрэгцээг хангаж эхэлсэн байна. | 2018-2022 | Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ | Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага Аж ахуй нэгж, иргэд |
| **4. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах** | | | | | | | |
| 12 | Бага, дунд оврын техникийн ашиглалт, зориулалт, шатахуун зарцуулалт, бүтээлийн норм, технологийн сургалтыг танхимд болон | Инженер, техникийн ажилтнуудыг чадвахжуулах, техник, технологийн шинэчлэл хийх, газар тариалангийн үйлдвэрлэлд ажиллаж байгаа мэргэжилтэн болон | Тариаланч, механикжуулагч ид, мэргэжилтнүүдийн ур чадвар нэмэгдсэн | 2018-2022 | Төсөл хөтөлбөр, иргэд аж ахуй нэгжийн хөрөнгө | ХХААГ | Сумын Засаг дарга нар, Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | усалгаа зэрэг дэвшилттэй технологи нэвтрүүлэх | нэмэгдүүлэх | | | | | |
| 7 | Услалтын системийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх | Тарагт, Төгрөг, Арвайхээр, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хархорин сумдын услалтын системүүдийн толгойн барилга, гол суваг, барилга байгууламжийг шинэчлэх сэргээн засварлах, ашиглагч, эзэмшигчийг тодорхой болгож, ашиглалтыг сайжруулж, бүртгэлжүүлэн хувийн хэрэгтэй болгох | Усалгаатай талбай суурь оноос 10 –аас доошгүй хувиар нэмэгдэж нэгж талбайн ургац 3-5 цн –ээр нэмэгдэнэ | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга нар | ХХААХҮЯ, Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага Аж ахуй нэгж, иргэд |
| 8 | Тариалын төрөлд зохицсон зориулалтын зоорь, агуулах байгуулах иргэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, импортыг бууруулах | Хархорин, Арвайхээр сумдад механикжсан болон, хүнсний ногооны төрөлжсөн зоорь байгуулах, борлуулалтын ложистик сүлжээг дэмжих | Хархорин, Арвайхээр суманд төмс, хүнсний ногооны хадгалалт борлуулалтын худалдааны төв байгуулагдсан байна. | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга нар | Аж ахуй нэгж, иргэд |
| 9 | Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ, бий болгох боломжийг бүрдүүлэх | Тариалан эрхлэгчдийг шинэ зах зээлтэй холбох, борлуулалтыг нэмэгдүүлэхэд Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | Орон нутгийн үйлдвэрлэлээр хүнсний ногооны дотоодын хэрэглээний 51,5 хувийг хангана | 2018-2022 | Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга | Аж ахуй нэгж, иргэд, Төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага Төрийн бус байгууллагууд |
| 10 | Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр төрийн бараа, | Орон нутагтаа үйлдвэрлэсэн органик бүтээгдэхүүнээр төсөвт | 2018-2022 | Улсын төсөв | Сумын Засаг дарга нар | Хөрөнгө оруулалт, хөгжлийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талбайд зохион байгуулах | үйлдвэрлэгчид, механикжуулагчдыг мэргэшүүлэх сургалтанд хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | байна | | | | ТББ, Мэргэжлийн холбоод |
| 13 | Дотооддоо үйлдвэрлэх шим болон биологийн бордоог хэрэглэх, хөрсний үржил шимийг сайжруулах, хашаажуулах технологийн сургалтыг бүсчлэн зохион байгуулах | Байгальд ээлтэй дэвшилтэт технологийн стандартад нийцсэн хөдөө аж ахуйд шинээр нэвтэрч буй техник, технологийн болон талбайн сургалт, сурталчилгааг шат дараатай зохион байгуулах | Сургалтуудыг чанартай зохион байгуулж, тариалалт болон ургац нэмэгдсэн байна. | 2018-2022 | Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ | ХХААХҮЯ, МСҮТөв, Мэргэжлийн холбоод, ОУБ болон ТББ-ууд, Аж ахуй нэгж, иргэд |
| 14 | Борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Алтан намар” үзэсгэлэн-худалдааг бүх сумдад зохион байгуулж, орон нутагт туршлага солилцох, үзүүлэх сургалт хийх | “Алтан намар” үзэсгэлэн худалдааг бүх сумдад жил бүр зохион байгуулж, хэвших | Үзэсгэлэнд оролцогчдын тоо, борлуулалтын орлого өссөн байна. | 2018-2022 | Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумын Засаг дарга нар | ХОХБТХ, Мэргэжлийн холбоод, ОУБ болон ТББ-ууд, Аж ахуй нэгж, иргэд |

-oOo-

Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/687 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

“ЖИМС ЖИМСГЭНЭ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээ | Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх үр дүн | Хугацаа | Санхүүжилт | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндсэн | Хамтрагч |
| **1. Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх, тарималын болон бүтээгдэхүүний нэр төрөл , үйлдвэрхлэлийг нэмэгдүүлэх , өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1 | Жимс, жимсгэнэ тариалах хураах хадгалах, боловсруулах үйлдвэр байгуулах, шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх | Хархорин суманд чацаргана хадгалах, боловсруулах үйлдвэр байгуулах, технологийн шинэчлэл хийхэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх | Чацарганы тариалалтыг нэмэгдүүлэх, экспортод гаргах боломжийг бүрдүүлэх | 2018-2022 | Хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /цаашид ХОХБТХ гэх/, Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид ХХААГ гэх/ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид ХХААХҮЯ гэх/, Аж ахуй нэгж, иргэд |
| 2 | Шинээр тариалж, ургуулан үр жимсээ тогтвортой өгч эхэлсэн мод, бутны тоогоор тарималын төрлөөс хамааруулан нэг удаагийн урамшуулал олгох | Жимс, жимсгэний аж ахуй эрхлэгчдийг урамшуулах аймгийн журам гаргах | Болзолт уралдаан зарлаж, урамшуулсан байна. | 2018-2022 | Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХОХБТХ, ХХААГ | Байгаль орчин аялал жуулчлалын газар /цаашид БОАЖГ гэх/ Сумын Засаг дарга нар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Жимс жимсгэний талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, услалтын систем шинээр байгуулах, орчин үеийн дуслын усалгааны тоног төхөөрөмж шинээр суурилуулах, тариалалт, хөрс боловсруулалт, хураалтыг механикжуулах, суулгац худалдан авах иргэд , аж ахуй нэгжид санхүүгийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх | Жимс, жимсгэний талбайг хашаажуулах, ойн зурвасыг хашиж хамгаалахад аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгоно | Жимс, жимсгэний талбай хамгаалагдсан байна. | 2018-2022 | Орон нутгийн төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумдын Засаг дарга нар | ХХААХҮЯ, БОАЖГ, Төсөл хөтөлбөр, ОУ-ын байгуулла-гууд, Аж ахуй нэгж, иргэд |
| | | Усалгааны дэвшилтэт арга технологи /дуслын, намираа, бороожуулагчийг/-ийг нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээлээр дэмжин усалгаатай тариаланг хөгжүүлэх замаар нэгжээс авах ургацыг нэмэгдүүлэх, | Жимс, жимсгэний ургац нэмэгдэнэ | 2018-2022 | Орон нутгийн төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ | ХХААХҮЯ, Сумдын Засаг дарга нар, Төсөл хөтөлбөр, ОУ-ын байгуулла-гууд, Аж ахуй нэгж, иргэд |
| | | Бүтээмж өндөртэй техникийн шинэчлэл хийх, өрхийн болон фермерийн хэрэгцээнд нийцсэн бага, дунд хүчин чадалтай техник тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас лизинг, хөнгөлөлттэй зээлээр дэмжих | Хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн байна. | 2018-2022 | Хөнгөлөлттэй зээл, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумдын Засаг дарга нар | ХХААХҮЯ, Төсөл хөтөлбөр, ОУ-ын байгуулла-гууд, Аж ахуй нэгж, иргэд |
| 4 | Жимс, жимсгэнэ тариалж ажлын байр олгосон иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөр зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, | Жимс, жимсгэний аж ахуй эрхлэж буй иргэд, аж ахуй нэгжүүдийг жижиг, дунд үйлдвэрийн сан болон бусад төсөл хөтөлбөрт хамруулах, тариалах, боловсруулах, хэрэглэх арга зүйн | Жимс, жимсгэнэ тариалах иргэд аж ахуй нэгжүүдийн тоо нэмэгдэнэ | 2018-2022 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /цаашид ХХҮГазар гэх/ | ХОХБТХ, ХХААГазар, Сумдын Засаг дарга нар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах | сургалтыг зохион байгуулах | | | | | |
| 5 | Жимс, жимсгэний тариалалтын талбайг тордон хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өрх хашаанд жимсний мод бут, тэр дундаа чацаргана тариалах иргэдийг дэмжих | Жимс, жимсгэнэ тариалагч аж ахуй нэгжүүдийн талбайн хөрсийг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, шинжилгэний дүнд үндэслэн сайжруулах, тогтвортой хамгаалах, жимс, жимсгэний нэр төрөл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах | Жимс, жимсгэнэ тариалсан талбайг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлээр нийт хэрэгцээний 5,7 хувийг хангана. | 2018-2022 | Сум, орон нутгийн төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумдын Засаг дарга нар | Мэргэжлийн холбоод, иргэд, аж ахуйн нэгжүүд |
| **2. “Жимс, жимсгэнийн таримлын сорт шалгаруулах, анхдагч үржүүлэг бойжуулаг суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй, нутагшсан сортын суулгацын хангамжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 6 | Бүсийн эрдэм шинжилгээний байгууллагууд, томоохон аж ахуй нэгжүүдийг түшиглэн жимс, жимсгэний төрөл, зүйлийн сорт нутагшуулах, анхдагч үржүүлэг, бойжуулага, суулгац үйлдвэрлэлийн ажлыг эрчимтэй явуулах | Хархорин ХКК –ийн жимсний мод үржүүлгийг түшиглэн бусад сумдад цэцэрлэгийн талбай бий болгох | Иргэдийн сонирхол нэмэгдэнэ, жимс, жимсгэний үйлдвэрлэлт өсөж үйл ажиллагаа сайжирна. | 2018-2022 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | ХХААГ | Хархорин ХХК, Эрдэм шинжилгээ-ний байгуулла-гууд |
| **3.“Жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилан цогц байдлаар хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 7 | Залгаж ургуулах аргаар үрт болон яст жимсний | Жимс, жимсгэний салбарын хэрэгцээт ажиллах хүчийг | Жимс, жимсгэний салбарын боловсон хүчний чадавхи | 2018-2022 | Төсөл хөтөлбөр, иргэд аж ахуй | ХХААГазар, Мэргэжлийн холбоод, | Сумдын Засаг дарга нар, Аж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах | сургалтыг зохион байгуулах | | | | | |
| 5 | Жимс, жимсгэний тариалалтын талбайг тордон хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өрх хашаанд жимсний мод бут, тэр дундаа чацаргана тариалах иргэдийг дэмжих | Жимс, жимсгэнэ тариалагч аж ахуй нэгжүүдийн талбайн хөрсийг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, шинжилгэний дүнд үндэслэн сайжруулах, тогтвортой хамгаалах, жимс, жимсгэний нэр төрөл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах | Жимс, жимсгэнэ тариалсан талбайг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлээр нийт хэрэгцээний 5,7 хувийг хангана. | 2018-2022 | Сум, орон нутгийн төсөв, Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, бусад хөрөнгө оруулалт | ХХААГ, Сумдын Засаг дарга нар | Мэргэжлийн холбоод, иргэд, аж ахуйн нэгжүүд |
| **2. “Жимс, жимсгэнийн тарималын сорт шалгаруулах, анхдагч үржүүлэг бойжуулаг суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй, нутагшсан сортын суулгацын хангамжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 6 | Бүсийн эрдэм шинжилгээний байгууллагууд, томоохон аж ахуй нэгжүүдийг түшиглэн жимс, жимсгэний төрөл, зүйлийн сорт нутагшуулах, анхдагч үржүүлэг, бойжуулага, суулгац үйлдвэрлэлийн ажлыг эрчимтэй явуулах | Хархорин ХКК –ийн жимсний мод үржүүлгийг түшиглэн бусад сумдад цэцэрлэгийн талбай бий болгох | Иргэдийн сонирхол нэмэгдэнэ, жимс, жимсгэний үйлдвэрлэлт өсөж үйл ажиллагаа сайжирна. | 2018-2022 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | ХХААГ | Хархорин ХХК, Эрдэм шинжилгээ-ний байгуулла-гууд |
| **3.“Жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилан цогц байдлаар хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 7 | Залгаж ургуулах аргаар үрт болон яст жимсний | Жимс, жимсгэний салбарын хэрэгцээт ажиллах хүчийг | Жимс, жимсгэний салбарын боловсон хүчний чадавхи | 2018-2022 | Төсөл хөтөлбөр, иргэд аж ахуй | ХХААГазар, Мэргэжлийн холбоод, | Сумдын Засаг дарга нар, Аж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үржүүлэг хийх, талбайд болон хүлэмжинд жимс жимсгэнэ тариалах, мод бутны таналт, тайралт, хэлбэржүүлэлтийг зохистой хийх арга технологийг эзэмшүүлэх чиглэлээр сургалтад хамруулж шинэ технологитой танилцах, туршлага судлах, тэдгээрийг нэвтрүүлэх | нарийвчлан судлаж, шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд зориулсан курс, төвүүдийн үйл ажиллагааг дэмжих замаар хүний нөөцийн чадавхи, залгамж халааг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлд ажиллаж байгаа мэргэжилтэн болон үйлдвэрлэгчдийг мэргэжшүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | сайжирч, шинэ технологи нэвтрүүлсэн байна. | | нэгжийн хөрөнгө | ТББ-ууд | ахуй нэгж иргэд |
| **4.“Салбарын маркетингийн стратегийг боловсруулж, дотоод болон гадаадын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 8 | Жимс, жимсгэний борлуулалтыг төрийн худалдан авалтаар /боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, байгууллагууд болон төрийн өмчийн аж ахуй нэгж/ дэмжих нөхцөлийг бүрдүүлэх | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр төрийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа орон нутагтаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд сонгон авах | Орон нутагтаа үйлдвэрлэсэн органик бүтээгдэхүүнээр төсөвт байгууллага хангагдаж, үйлдвэрлэгчдийн борлуулалт нэмэгдсэн байна | 2018-2022 | Орон нутгийн төсөв | ХХААГазар Сумдын Засаг дарга нар | Орон нутгийн өмчийн хэлтэс, Төсөвт байгуулла-гууд, Аж ахуй нэгж, иргэд |

-oOo-